Төлөвлөгөөг баталсан:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

................ (Л.БЯМБАСҮРЭН)
(гарын үсэг)

................
(огноо)

Төлөвлөгөө боловсруулсан:

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА

НЭГЖИЙН ДАРГА

................ (С.ДОЛГОРСҮРЭН)
(гарын үсэг)

2024.03.07.
(огноо)

# ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2024 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах албан хаагч |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго 1.** Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ. | | | | | | | |
| Зорилт 1.2.Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана. | | | | | | | |
| 1.2.1 | *БГТ 1.2.3*<br>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | - | Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | - | Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. | I-IV улирал | С.Долгорсүрэн<br>Д.Гансүрэн<br>Ө.Түмэнжаргал |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.2 | *БГТ 1.2.4* Эрүүл мэндийн даатгалын 2022, 2023 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна. | - | Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо | - | Статистик мэдээллийг олон нийтэд түгээн сурталчилах арга хэмжээг зохион байгуулсан байна. | I-IV улирал | С.Долгорсүрэн Д.Гансүрэн Ө.Түмэнжаргал |
| 1.2.3 | "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | - | Шинэчлэн баталсан тогтоолыг хүргүүлсэн ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо | ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолыг мөрдөж байна. | Журмыг хэрэгжүүлсэн байна. | I-IV улирал | С.Долгорсүрэн Д.Гансүрэн Ө.Түмэнжаргал |
| 1.2.4 | ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | - | Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо | ЭМДҮЗ 2023 оны 06 дугаар тогтоолыг мөрдөж байна. | Хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлагнасан байна. | I-IV улирал | С.Долгорсүрэн Д.Гансүрэн Ө.Түмэнжаргал |
| 1.2.5 | Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, | - | -Санхүүжүүлсэн мөнгөн дүн | Хамрагдсан даатгуулагчийн тоо 3350, | Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-уудын | I-IV улирал | С.Долгорсүрэн Д.Гансүрэн Ө.Түмэнжаргал |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана. | | -Хамрагдсан даатгуулагчийн тоо | Санхүүжүүлсэн мөнгөн дүн 415,8 сая төгрөг | гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна. | | |
| 1.2.6 | ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлнэ. | - | Хийсэн дүн шинжилгээний тоо, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн саналын тоо | - | Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна. | II, IV улирал | С.Долгорсүрэн<br>Д.Гансүрэн<br>Ө.Түмэнжаргал |
| Зорилт 1.4. Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно: | | | | | | | |
| 1.4.1 | *БСТ 2.1.3, БГТ-1.4.3*<br>Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө. | - | Хүргүүлсэн саналын тоо | 2 санал хүргүүлсэн. | Эрх зүйн баримт бичигт холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн байна. | I-IV улирал | С.Долгорсүрэн<br>Д.Гансүрэн<br>Ө.Түмэнжаргал |
| 1.4.2 | Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, Прокурорын байгууллагатай хамтран ажиллана. | - | Зөрчлийн хэргийн тоо Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн | - | Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна. | I-IV улирал | С.Долгорсүрэн<br>Д.Гансүрэн |
| **Зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.** | | | | | | | |
| Зорилт 2.1. Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлнэ. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.1 | *ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7, БГТ 2.1.1*<br>Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2023 оны хамрагдалтын хувь 59. | Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 2024 онд 65. | I-IV улирал | С.Долгорсүрэн<br>Д.Гансүрэн<br>Ө.Түмэнжаргал |
| | | | Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2023 оны хамрагдалтын хувь 18. | Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 2024 онд 25. | | |
| | | | Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь | 2023 оны хамрагдалтын хувь 138. | Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь 2024 онд 100. | | |
| | | | -Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь | 2023 оны хамрагдалтын хувь 100. | -Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь 2024 онд 100. | | |
| 2.1.2 | Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ. | - | Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо | 2023 онд сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих тайланг 4 удаа гарган хүргүүлсэн. | Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган хүргүүлсэн байна. | I-IV улирал | С.Долгорсүрэн<br>Д.Гансүрэн<br>Ө.Түмэнжаргал |
| 2.1.3 | *ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7,*<br>Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж, тайлагнана. | | Төвлөрүүлсэн мөнгөн дүн | 2023 оны орлогын төлөвлөгөөний биелэлт 98,5% хувьтай байна. | ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 98-аас доошгүй хувь хэрэгжүүлэн ажилласан байна. | I-IV улирал | С.Долгорсүрэн<br>Д.Гансүрэн<br>Ө.Түмэнжаргал |
| Зорилт 2.2. Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.1 | *БСТ 2.2.1, БГТ-2.2.1*<br><br>Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна. | ЭМДС | Өглөг, авлагын тоо хэмжээ, тайлан | 2 ЭМБ-д 63 сая төг авлагатай. | Өглөг, авлага барагдуулах чигэлээр арга хэмжээ авч ажилласан байна | I-IV улирал | С.Долгорсүрэн<br>Д.Гансүрэн<br>Ө.Түмэнжаргал |
| **Зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна** | | | | | | | |
| Зорилт 3.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна. | | | | | | | |
| 3.1.1 | *БСТ 3.1.2, БГТ 3.1.1*<br><br>Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн сангуудын 2023 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна. | - | Гэрээ дүгнүүлсэн байгууллагын тоо | 42 гэрээт эрүүл мэндийн байгууллагыг дүгнэсэн. | Гэрээт ЭМБ-уудын гэрээг хагас, бүтэн жилээр хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг | I-IV улирал | С.Долгорсүрэн<br>Д.Гансүрэн<br>Ө.Түмэнжаргал |
| | | | Гэрээний хэрэгжилтийн хувь | Гэрээний хэрэгжилт 69,2 хувь | Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна. Гэрээний биелэлтийн хувь 90 хувиас доошгүй. | I улирал | С.Долгорсүрэн<br>Д.Гансүрэн<br>Ө.Түмэнжаргал |
| Зорилт 3.2. Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна | | | | | | | |
| 3.2.1 | *БГТ 3.2.1*<br>Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ. | Э<br>М<br>Д<br>С | Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, нэхэмжилсэн даатгуулагчийн тоо, мөнгөн дүн, | Нийт давхардсан тоогоор 41 ЭМБ 108081 хүний 12,9 тэрбум төгрөгийн нэхэмжлэлийн гүйцэтгэл хянагдсан. | Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг журмын дагуу хэрэгжүүлсэн байна. | I-IV улирал | С.Долгорсүрэн<br>Д.Гансүрэн<br>Ө.Түмэнжаргал |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.2 | *БГТ 3.2.3*<br>Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ. | - | Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо | 2023 онд 8 ЭМБ-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. | Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна. | I-IV улирал | С.Долгорсүрэн<br>Д.Гансүрэн<br>Ө.Түмэнжаргал |
| 3.2.3 | Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангуулна. | - | Хүргүүлсэн зөвлөмжийн тоо<br>Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 17 эрүүл мэндийн байгууллагад 27 улсын ахлах байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн. Хэрэгжилт-85 хувь. | Тусламж, үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна. | I-IV улирал | С.Долгорсүрэн<br>Д.Гансүрэн |
| 3.2.4 | *БСТ 3.2.3, БГТ-3.2.2*<br>Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, саналд үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ. | - | Газар дээрх хяналт, шалгалт хийсэн ЭМБ-ын тоо<br>Хяналт, шалгалтын тайлан | - | Газар дээрх хяналт, шалгалт хийж тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна. | I-IV улирал | С.Долгорсүрэн<br>Д.Гансүрэн<br>Ө.Түмэнжаргал |
| **Зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.** | | | | | | | |
| Зорилт 4.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө. | | | | | | | |
| 4.1.1 | *ЗГҮАХ-2.1.9, БГТ 4.1.3*<br>Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутагтай хамтарч хэрэгжүүлнэ. | - | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, тайлан | Хэрэгжүүлсэн арга хэмжээ-1. | Арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. | I-IV улирал | С.Долгорсүрэн |
| 4.1.2 | *БГТ 4.1.4* | - | Хамрагдсан сургалтын тоо | ЭМДЕГ-аас зохион байгуулсан | Ерөнхий газраас зохион байгуулах | I-IV улирал | Нийт албан хаагчид |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Ерөнхий газраас баталсан Сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана. | | | сургалтад тогтмол хамрагдсан. | нийт сургалтад тогтмол хамрагдаж мэдээлэл авсан байна. | | |
| 4.1.3 | Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг,сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын тоо | Зохион байгуулсан арга хэмжээ-12 | Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна. | I-IV улирал | С.Долгорсүрэн Д.Гансүрэн Ө.Түмэнжаргал |
| 4.1.4 | Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ. | - | Иргэд, даатгуулагчдад хүргэсэн мэдээлэл, хандалтын тоо | 2023 онд 437 иргэн даатгуулагчдыг мэдээллээр хангасан | 40-с доошгүй Иргэн даатгуулагчдад мэдээлэл хүргэсэн байна. | I-IV улирал | С.Долгорсүрэн Д.Гансүрэн Ө.Түмэнжаргал |
| 4.1.5 | *БГТ 4.1.8* Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ. | - | Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо | 2023 онд 150 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан | Сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна. | II , IV улирал | Д.Гансүрэн Ө.Түмэнжаргал |
| 4.1.6 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана. | - | Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь | Өргөдөл, гомдлын тоо 417 шийдвэрлэлт 100 хувь | Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг ерөнхий | I-IV улирал | Д.Гансүрэн Ө.Түмэнжаргал |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газарт хүргүүлсэн байна. | | |
| 4.1.7 | Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, цаг бүртгэлд хяналт тавих, ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөн туслах, чиглүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний | Хэлтсийн мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж гүйцэтгэлийг хагас болон бүтэн жилээр дүгнэж ЭМДЕГ-т хүргүүлэн ажилласан | Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна. | I-IV улирал | С.Долгорсүрэн |
| 4.1.8 | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлж, ЭМДЕГ-ын архивт хугацаанд хүлээлгэж өгнө. | - | Бүрдүүлсэн архивын нэгжийн тоо | 2023 онд 28 боть архивын нэгж үүсгэсэн. | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлсэн байна | I- улирал | С.Долгорсүрэн<br>Д.Гансүрэн<br>Ө.Түмэнжаргал |
| 4.1.9 | Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаан, цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнана. | - | Хугацаанд нь тайлагнасан үүрэг даалгаврын тоо, хэрэгжилтийн хувь. | Өгөгдсөн үүрэг даалгаварыг 100 хувь хэрэгжүүлсэн | Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнасан байна. | I-IV улирал | С.Долгорсүрэн<br>Д.Гансүрэн<br>Ө.Түмэнжаргал |

-ooOoo-

# ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН



## ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024 оны 11 дүгээр сарын 27 Мандалговь хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | | |
| **Зорилго 1.** Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ. | | | | | | | |
| Зорилт 1.2.Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана. | | | | | | | |
| 1.2.1 | *БГТ 1.2.3*<br>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | - | Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | | Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. | Гэрээт 39 эрүүл мэндийн байгууллагуудтай "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ"-г байгуулан 14 төрлийн тусламж үйлчилгээнд нэхэмжлэлийн хяналт хийж сар бүр хяналтаар илэрсэн зөрчлийн дагуу эрүүл мэндийн байгууллагуудад албан бичгээр тайлбар мэдээлэл хүргүүлэн лавлагаа шатлалын 3 эрүүл мэндийн байгууллагад тэнхимээр 5, анхан шатны эрүүл мэндийн байгуулагуудад цахимаар 4, тэнхимээр 5 удаа сургалт мэдээлэл, аймгийн гэрээт лавлагаа шатлалын 2 эмнэлэгт эрүүл мэндийн улсын ахлах байцаагчийн зөвлөмж өгч ажилласанаар зөрчлийн тоо 2023 оны 11 сарын үзүүлэлтээс 46,4 хувиар буурч, мөнгөн дүн 0,4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Зөрчлийн тохиолдлын тоо эмчийн хасалт 40,3 хувиар буурч, байцаагчийн хасалт 281 хувиар өсч, эх олонлоги 28,6 хувиар өссөн байна.<br>Задаргаар графикаар үзүүлвэл:<br> | 100 |


2023 оны 11 сар, 2024 оны 11 сарын
зөрчлийн мөнгөн дүн
Нийт дүн
эх олонлог
цахим хасалт
байцаагчийн хасалт
эмчийн хасалт
764.6
761.6
242.6
212.9
293.2
273.5
19.7
49.6
209.1
225.6
0% 20% 40% 60% 80% 100%
2023.11
2024.11
эмчийн хасалт
байцаагчийн хасалт
цахим хасалт
эх олонлог
Нийт дүн
2023.11 209.1 19.7 293.2 242.6 764.6
2024.11 225.6 49.6 273.5 212.9 761.6


2023 оны 11 сар, 2024 оны 11 сарын
зөрчлийн мөнгөн дүн / саяар/
2500
2000
1500
1000
500
0
2066
764.6
1108
761.6
2023.11
2024.11
зөрчлийн тоо
зөрчлийн мөнгөн дүн

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.2 | *БГТ 1.2.4* Эрүүл мэндийн даатгалын 2022, 2023 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна. | - | Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо | - | Статистик мэдээллийг олон нийтэд түгээн сурталчилах арга хэмжээг зохион байгуулсан байна. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Эрүүл мэндийн даатгалын 2022, 2023 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэл ирээгүй байгаа бөгөөд сар бүр гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилтийн мэдээллийг аймгийн засаг дарга болон Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлж ажилладаг. | 100 |
| 1.2.3 | "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | - | Шинэчлэн баталсан тогтоолыг хүргүүлсэн ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо | ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолыг мөрдөж байна. | Журмыг хэрэгжүүлсэн байна. | 2023 онд батлагдсан ЭМДҮЗ-ийн 10 дугаар тогтоол, 2024 онд шинээр батлагдсан 05,06 тогтоолыг гэрээ бүхий лавлагаа шатлалын 3, анхан шатны 17 эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд Бодлого төлөвлөлтийн газраас зохион байгуулсан тогтоолын шинэчлэлийн 11 удаагийн цахим сургалтад бүрэн хамруулсан. Тогтоолын шинэчлэлтэй холбоотой гэрээт эрүүл мэндийн байгууллагуудаас ирсэн асуултад хариулж өгч мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөн ажиллаж байна. Гэрээт лавлагаа шатлалын 3, анхан шатны 20 эрүүл мэндийн байгууллагад тогтоолыг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | 100 |
| 1.2.4 | ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | - | Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо | ЭМДҮЗ 2023 оны 05 дугаар тогтоолыг мөрдөж байна. | Хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлагнасан байна. | Анхан шатны 17 эрүүл мэндийн байгууллагуудад тогтоолыг хүргүүлэн тэнхимээр 5, цахимаар 4 удаагийн сургалт мэдээлэл өгч мэргэжил арга зүйгээр хангаж сар бүр хэрэгжилтэд хяналт, дүн шинжилгээ хийн цахим хэлбэрээр 17 эрүүл мэндийн байгууллагын удирдлага, эмч мэргэжилтнүүдэд нэхэмжлэлийн хяналтаар илэрсэн зөрчил, анхаарах асуудлаар мэдээлэл бгч оролцогчдын сонирхсон асуултад хариулт өгч ажиллаж байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.5 | Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана. | - | -Санхүүжүүлсэн мөнгөн дүн<br>-Хамрагдсан даатгуулагчийн тоо | Хамрагдсан даатгуулагчийн тоо 3350, Санхүүжүүлсэн мөнгөн дүн 415,8 сая төгрөг | Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-уудын гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна. | Одоогийн байдлаар нэгдсэн эмнэлэг нь "Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг"-ээр гэрээлэн ажиллаж байгаа бөгөөд 2024 оны эхний 10 сарын байдлаар 1107 иргэн даатгуулагчийг эрт илрүүлэг үзлэгт хамруулан цахим хяналтаар 13,2 сая төгрөг хасагдан 168,595,000.0 төгрөгийн санхүүжилт олгосон байна. | 100 |
| 1.2.6 | ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлнэ. | - | Хийсэн дүн шинжилгээний тоо, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн саналын тоо | - | Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна. | Гэрээ бүхий эрүүл мэндийн байгуулагуудын гүйцэтгэлд сар бүр нэхэмжлэлийн хяналтыг хийж гүйцэтгэн нэхэмжлэлийн мөнгөн дүн, хяналтаар илэрч буй зөрчлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад мэдээлэл, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөөс гадна Бодлого төлөвлөлтийн газрын холбогдох мэргэжилтэнд цахимаар хянах боломжтой саналыг уламжилж шийдвэрлүүлж ажилласан. Тухайлбал анхан шатны эрүүл мэндийн байгууллагад ЭМДҮЗ-ийн 2023 оны 06 дугаар тогтоолын сэргээн засах, өдрийн эмчилгээний тохиолдлын 5 хүртэлх хоногоор цахимд шивэх боломжтой 5-аас дээш хоногийн тохтолдлыг эрүүл мэндийн байгууллагууд 2 тохиолдлоор нэхэмжилж хасагдлын тоо, мөнгөн дүн өсөх хандлагыг БТГ-ын ахлах мэргэжилтэн Б.Янжиндолгорт уламжилж 5-аас дээш хоног байхаар цахимд хөгжүүлэлт хийлгэсэн. Мөн Бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн болон Тусламж үйлчилгээ, багц зохицуулалтын хэлтсийн теллеграмм группт анхан шатны тусламж үйлчилгээнд давхардлыг цахимаар хянаж хасагдлыг тооцдог болохыг уламжилж тус газар нь МТХ-т бодлогын даалгавар хүргүүлэхээр болсон. | 95 |
| Зорилт 1.4. Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно: | | | | | | | |
| 1.4.1 | *БСТ 2.1.3, БГТ-1.4.3*<br>Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө. | - | Хүргүүлсэн саналын тоо | 2 санал хүргүүлсэн. | Эрх зүйн баримт бичигт холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн байна. | ЭМДҮЗ-ийн 12 дугаар тогтоолын төсөлд 5 санал, 06 дугаар тогтоолын төсөлд 2 санал тус тус дотоод албан бичгээр хүргүүлсэн. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4.2 | Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, Прокурорын байгууллагатай хамтран ажиллана. | - | Зөрчлийн хэргийн тоо Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн | - | Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна. | Аймгийн прокурорын байгууллагатай хамтран ажиллаж Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн 12.1.1 дэх заалтад заасны дагуу гэм буруутай этгээдээс төлбөрийг гаргуулахаар<br>Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 24 иргэний өргөдөл гарган эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаанд нэхэмжлэгчээр оролцон 6.280.500 төгрөгийн Эрүүл мэндийн даатгалын санд нөхөн төлүүлж хохирлыг барагдуулан Дундговь аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүгчийн захирамжаар баталгаажуулсан. Мөн 2024 оны 11 сарын 18 нд аймгийн прокурорын газарт 2024 онд гэм буруутай этгээдийн улмаас эрүүл мэнд нь хохирч тусламж үйлчилгээ авсан 67 иргэний 39,751,319 төгрөгийн лавлагаа гарган хүргүүлсэн байна. | 100 |
| **Зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.** | | | | | | | |
| Зорилт 2.1. Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 2.1.1 | *ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7, БГТ 2.1.1*<br><br>Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | | Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2023 оны хамрагдалтын хувь 59. | Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 2024 онд 65. | 2024 оны 11 сарын 18 ны байдлаар:<br>Малчин 5852 хамруулахаас 3054 биелэлт-52,1,7% | 52,1 |
| | | | Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2023 оны хамрагдалтын хувь 18. | Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 2024 онд 25. | Хамруулвал зохих 171, хамрагдсан 939, биелэлт 549,1%. | 549,1 |
| | | | Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь | 2023 оны хамрагдалтын хувь 138. | Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь 2024 онд 100. | Хамруулвал зохих 1286, хамруулсан 1779, биелэлт 139,8%. | 139,8 |
| | | | -Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь | 2023 оны хамрагдалтын хувь 100. | -Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь 2024 онд 100. | Ажил олгогчийн тоо-7179, мөнгөн дүн- 4,1 тэрбум. Биелэлт 89,1 хувь. | 89,1 |

<table>
<tr><td>2.1.2</td><td>Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ.</td><td>-</td><td>Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо</td><td>2023 онд сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих тайланг 4 удаа гарган хүргүүлсэн.</td><td>Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган хүргүүлсэн байна.</td><td>2024 оны Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавин Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/355 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайланг улирал тутам гарган нэгтгэж 3 удаа Санхүү бүртгэлийн хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн.</td><td>100</td></tr>
<tr><td>2.1.3</td><td>ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7, Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж, тайлагнана.</td><td></td><td>Төвлөрүүлсэн мөнгөн дүн</td><td>2023 оны орлогын төлөвлөгөөний биелэлт 98,5% хувьтай байна.</td><td>ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 98-аас доошгүй хувь хэрэгжүүлэн ажилласан байна.</td><td>ЭМДЕГ-ын даргын 2024 оны А/15 тоот тушаалын дагуу аймгийн 15 сумдын засаг дарга нарт хамралтын төлөвлөгөө болон хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх үр дүнг тооцох албан бичгийг хүргүүлж ажиллалаа. Орлогын төлөвлөгөөний биелэлт 89,3%.
<table>
<tr><th rowspan="2">№</th><th rowspan="2">Даатгуулагчийн төрөл</th><th colspan="2">Төлөвлөгөө</th><th colspan="2">Биелэлт</th></tr>
<tr><th>Тоо</th><th>Мөнгөн дүн</th><th>Тоо</th><th>Мөнгөн дүн</th></tr>
<tr><td>1</td><td>Ажил олгогч</td><td></td><td>4,673,961,600</td><td>7194</td><td>4,158,000,000</td></tr>
<tr><td>2</td><td>ААН, ХХЭ ажилгүй иргэд</td><td>1286</td><td rowspan="4">564,325,700</td><td>1799</td><td>134,646,500</td></tr>
<tr><td>3</td><td>Оюутан</td><td>171</td><td>939</td><td>73,945,900</td></tr>
<tr><td>4</td><td>Малчин</td><td>5852</td><td>3054</td><td>312,569,800</td></tr>
<tr><td>5</td><td>Гадаадын иргэн</td><td>1</td><td>40</td><td>3,418,600</td></tr>
<tr><td>6</td><td>Нийт</td><td>7310</td><td>5,238,287,300</td><td>5832</td><td>4,682,580,800</td></tr>
</table></td><td>89.3</td></tr>
<tr><td colspan="8">Зорилт 2.2. Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална.</td></tr>
<tr><td>2.2.1</td><td>БСТ 2.2.1, БГТ-2.2.1<br>Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна.</td><td>ЭМДС</td><td>Өглөг, авлагын тоо хэмжээ, тайлан</td><td>2 ЭМБ-д 63 сая төг авлагатай.</td><td>Өглөг, авлага барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна</td><td>Аймгийн хэмжээнд 39 эрүүл мэндийн байгууллагатай "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ" байгуулан гүйцэтгэлд нэхэмжлэлийн хяналт хийж ажиллаж байна. 2024 оны 11 сарын 23 ны байдлаар 1 эрүүл мэндийн байгууллагаас 447 сая төгрөг, 20 эрүүл мэндийн байгууллагад 947 сая төгрөгийн өглөгтэй байна. Авлага нь нэгдсэн эмнэлэгт урьдчилгаа санхүүжилт олгосонтой холбоотой авлага үүссэн байна.</td><td>100</td></tr>
</table>

<table>
<tr><th colspan="8">Зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна</th></tr>
<tr><td colspan="8">Зорилт 3.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна.</td></tr>
<tr><td rowspan="2">3.1.1</td><td rowspan="2">БСТ 3.1.2, БГТ 3.1.1<br>Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн сангуудын 2023 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна.</td><td rowspan="2"></td><td>Гэрээ дүгнүүлсэн байгууллагын тоо</td><td>42 гэрээт эрүүл мэндийн байгууллагыг дүгнэсэн.</td><td rowspan="2">Гэрээт ЭМБ-уудын гэрээг хагас, бүтэн жилээр хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна. Гэрээний биелэлтийн хувь 90 хувиас доошгүй.</td><td rowspan="2">2023 онд "Эрүүл мндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ" байгуулсан 42 эрүүл мэндийн байгууллагаас Мөнхдэлгэр хувийн эмнэлэг нь өөрийн хүсэлтээр гэрээ цуцлуулж 41 эрүүл мэндийн байгуулллагыг гэрээг ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/61 тоот тушаалын дагуу дүгнэн нэгтгэл дүгнэлтийг ХАГГ-т хүргүүлсэн. Дүгнэлт саналын дагуу 3 эмийн сангийн гэрээг түдгэлзүүлж 9 сумын эрүүл мэндийн байгууллагад Эрүүл мэндийн даатгалын улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг хүргүүлж ажилласан.<br>Лавлагаа шатлалын гэрээний биелэлтийн дундаж 98%.<br>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын гэрээний биелэлтийн дундаж 79,3%.<br>Эмийн сангийн гэрээний биелэлтийн дундаж 85,2%.</td><td rowspan="2">87,3</td></tr>
<tr><td>Гэрээний хэрэгжилтийн хувь</td><td>Гэрээний хэрэгжилт 69,2 хувь</td></tr>
<tr><td colspan="8">Зорилт 3.2. Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна.</td></tr>
<tr><td>3.2.1</td><td>БГТ 3.2.1<br>Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.</td><td>ЭМДС</td><td>Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, нэхэмжилсэн даатгуулагчийн тоо, мөнгөн дүн,</td><td>Нийт давхардсан тоогоор 41 ЭМБ 108081 хүний 12,9 тэрбум төгрөгийн нэхэмжлэлийн гүйцэтгэл хянагдсан.</td><td>Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг журмын дагуу хэрэгжүүлсэн байна.</td><td>Гэрээ бүхий 39 эрүүл мэндийн байгууллагуудаас гүйцэтгэлийн нэхэмжлэлийн сар бүрийн 05 ны дотор dua-invoice@emd.gov.mn хүлээн авч гүйцэтгэлд нэхэмжлэлийн хяналт хийж гүйцэтгэж олгох санхүүжилтийн нэгтгэлийг 20 ны дотор хүргүүлдэг.
<table>
<tr><th rowspan="2">№</th><th rowspan="2">Эрүүл мэндийн байгууллагын нэр</th><th rowspan="2">тоо</th><th rowspan="2">Нэхэмжилсэн</th><th colspan="2">Хасагдсан</th></tr>
<tr><th>тоо</th><th>олгох</th></tr>
<tr><td>1</td><td>Улсын эмнэлэг</td><td>90,711</td><td>9,211,521,484</td><td>1,689</td><td>568,154,336</td></tr>
<tr><td>2</td><td>төр хариуцах эм</td><td>963</td><td>20,252,362</td><td>0</td><td>0</td></tr>
<tr><td>3</td><td>УС-х</td><td>1,107</td><td>181,820,000</td><td>33</td><td>13,225,000</td></tr>
<tr><td>4</td><td>хувийн эмнэлэг</td><td>142</td><td>75,715,736</td><td>0</td><td>0</td></tr>
<tr><td>5</td><td>ӨСЭМТ хуучин 4</td><td>5,333</td><td>306,151,000</td><td>69</td><td>8,349,500</td></tr>
<tr><td>6</td><td>ӨСЭМТ шинэ 4</td><td>12,322</td><td>2,338,986,470</td><td>470</td><td>171,898,174</td></tr>
<tr><td>7</td><td>ЭМИЙН САН</td><td>27,363</td><td>755,219,960</td><td>0</td><td>161,044</td></tr>
<tr><td></td><td>Нийт дүн</td><td>137,941</td><td>12,889,667,012</td><td>2,261</td><td>761,788,054</td></tr>
</table></td><td>100</td></tr>
</table>

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>Тус хэлтсийн нийт албан хаагчдад 2024 оны эхний 10 сарын байдлаар нийт 256 эрүүл мэндийн байгууллагын 20629 түүвэр хуваарилагдсан бөгөөд түүвэрт нэхэмжлэлийн хяналт хийж 3945 зөрчил илрүүлж 832,2 сая төгрөгийн хасагдал хийсэн байна.
<table>
<tr><th>№</th><th>Албан хаагчдын нэрс</th><th>Хуваар илагдсан ЭМБ-ын тоо</th><th>Түүврийн тоо</th><th>Илрүүсэн зөрчлийн тоо</th><th>Хасагдлын Мөнгөн дүн</th></tr>
<tr><td>1</td><td>С.Долгорсүрэн</td><td>103</td><td>4633</td><td>475</td><td>410,035,001</td></tr>
<tr><td>2</td><td>Д.Гансүрэн</td><td>78</td><td>8491</td><td>2564</td><td>303,747,798</td></tr>
<tr><td>3</td><td>Ө.Түмэн-Өлзий</td><td>75</td><td>7505</td><td>906</td><td>118,500,000</td></tr>
<tr><td>4</td><td>Нийт</td><td>256</td><td>20629</td><td>3945</td><td>832,282,799</td></tr>
</table>
</td><td></td></tr>
<tr><td>3.2.2</td><td>БГТ 3.2.3<br>Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.</td><td>-</td><td>Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо</td><td>2023 онд 8 ЭМБ-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.</td><td>Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.</td><td>Гэрээ бүхий 39 эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан өдөр тутам утсаар болон биеэр хандсан эмч, мэргэжилтнүүдэд зөвлөн туслаж мэргэжил арга зүйгээр хангаж ажилладаг.<br>2024 оны 01 сард Нэгдсэн эмнэлэг дээр очин амбулатори болон дэмжих тевийн өдөр тумын үйл ажиллагаатай танилцан эмч мэргэжилтнүүдийн сонирхсон асуултад хариулан иргэд даатгуулагчдаас тус эмнэлэгийн хүлээгдэл тусламж үйлчилгээний талаарх санал хүсэлтийг хүлээн авч ярилцаж эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг мөн 2024 оны 09 сарын 19 нд Азийн хөгжлийн банкны зөвлөхүүд болон ЭМДЕГ-ын БТГ, МТХ-ийн дарга нартай хамтран тус эмнэлэгийн гүйцэтгэлийн нэхэмжлэл, цахим хөгжүүлэлт, нэхэмжлэлийн хяналтын мэдээлэл, санхүүжилтийн мэдээлэл тус бүр дээр ажиллаж зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулан эмч, ажилчдын сонирхсон асуултад хариулт өгч ажилласан. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын 17, лавлагаа шатлалын 3 нийт 20 эрүүл мэндийн байгууллагад өдөр тутам болон сар бүр гүйцэтгэлд нэхэмжлэлийн хяналттай холбоотой илэрч буй зөрчил анхаарах асуудлаар зөвлөн тусалж мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаж байна.</td><td>100</td></tr>
<tr><td>3.2.3</td><td>Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай</td><td>-</td><td>Хүргүүлсэн зөвлөмжийн тоо<br>Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь</td><td>17 эрүүл мэндийн байгууллагад 27 улсын ахлах байцаагчийн зөвлөмж</td><td>Тусламж, үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.</td><td>2024 оны 11 сарын байдлаар 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлд хийсэн нэхэмжлэлийн хяналтын зөрчлийн дагуу лавлагаа шатлалын 2 эрүүл мэндийн байгууллагад, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад нэгдсэн нэг эрүүл мэндийн улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг хүргүүлэн мөн сар бүр гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад албан тоотоор болон</td><td>100</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутагтай хамтарч хэрэгжүүлнэ. | | | | | бүрдүүлсэн бөгөөд албан хаагчдын сэтгэл ханамж дээшилж ажлын бүтээмж нэмэгдсэн байна. | |
| 4.1.2 | *БГТ 4.1.4*<br><br>Ерөнхий газраас баталсан Сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана. | - | Хамрагдсан сургалтын тоо | ЭМДЕГ-аас зохион байгуулсан сургалтад тогтмол хамрагдсан. | Ерөнхий газраас зохион байгуулах нийт сургалтад тогтмол хамрагдаж мэдээлэл авсан байна. | ЭМДЕГ-аас зохион байгуулсан 16 удаагийн сургалт, мэдээллийн цаг хөтөлбөрт 9 удаа хамрагдаж мэдлэгээ бататгаж мэдээлэлээр хангагдсан байна. | 100 |
| 4.1.3 | Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг,сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын тоо | Зохион байгуулсан арга хэмжээ-12 | Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна. | Иргэд даатгуулагч аж ахуй нэгж байгууллагуудад "Эрүүл мэндийн даатгалын ач холбогдол", "Шинэчилсэн тогтоолын төслийн танилцуулга, иргэ даатгуулагчийн хариуцлага" сэдвээр 11 удаагийн танхимийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 650 гаруй иргэн даатгуулагчдыг хамруулсан байна.<br>Хэлтсийн https://www.facebook.com/profile.php?id=100080497560994 пэйжээр агентлагийн пэйж дээрх мэдээллийн тухай бүр өөрийн пэйжид нийтлэн сурталчилж бусад салбарын болон аймгийн зарын группүүдэд шэйрлэн түгээж байна. Нийт 454 пост мэдээллийг нийтэлсэн байна. 8768 үзэлттэй байна. Дагагчийн тоо-517. | 95 |
| 4.1.4 | Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ. | - | Иргэд, даатгуулагчдад хүргэсэн мэдээлэл, хандалтын тоо | 2023 онд 437 иргэн даатгуулагчдыг мэдээллээр хангасан | 40-с доошгүй Иргэн даатгуулагчдад мэдээлэл хүргэсэн байна. | 14 хоног тутам аймгийн засаг даргын тамгын газрын удирдлагын шуурхай хуралд хэлтсийн 14 хоногийн ажлын тайлан, цаг үеийн бусад ажлыг танилцуулан мэдээлэл өгч хэвшсэн.<br>Мэдээллийн самбарт гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилтийн мэдээллийг сар бүр байршуулан иргэд даатгуулагч аж ахуй нэгж байгууллагуудад "Шинэчилсэн тогтоолын төслийн танилцуулга, иргэд даатгуулагчийн хариуцлага" сэдвээр 9 удаагийн танхимийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 540 гаруй иргэн даатгуулагчдыг хамруулсан байна. | 95 |
| 4.1.5 | *БГТ 4.1.8*<br>Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, | - | Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо | 2023 онд 150 иргэнээс сэтгэл | Сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгдсэн тайланг | Хэлтсийн фэйсбүүк пэйж болон гэрээт 39 эрүүл мэндийн байгууллагуудын фэйсбүүк групп чатаар сэтгэл ханамжийн судалгааны линк илгээн цахимаар мөни иргэд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ. | | | ханамжийн судалгаа авсан | ерөнхий газарт хүргүүлсэн байна. | даатгуулагчдад тэнхимийн сургалт хийхдээ болон эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж байхдаа гүүгл форумаар сэтгэл ханамжийн асуумжыг бөглүүлэн дүгнэлт хийж ажиллалаа.<br>ЭМДХ-ийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр тийт 126 иргэн даатгуулагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэн дүгнэвэл:<br>1. Судалгаанд хамрагдсан нийт иргэн даатгуулагчдын 81,7% нь эмэгтэй, 18,3% нь эрэгтэй.<br>2. Таны нас?<br>➢ 31-45 насны -48,3%<br>➢ 46-60 нас 29,2%<br>➢ 18-30 нас 15,8%<br>➢ 60 наснаас дээш 6,7%<br>3. ЭМДХ-тэй сүүлийн хагас жилийн хугацаанд ямар асуудлаар хандсан бэ?<br>➢ ЭМД-ын шимтгэл төлөлттэйхолбоотой лавлагаа, үйлчилгээ авсан-27,9%<br>➢ Эмийн үнийн хөнгөлөлтийн талаар 23%<br>➢ ЭМДЕГ-тай гэрээт ЭМБ-н талаар-21,3%<br>➢ Өргөдөл, гомдол, хүсэлт шийдвэрлүүлсэн-3,3%<br>➢ Бусад-14,8%<br>4. ЭМДХ-ээс үйлчилгээ авахад хүндрэл байсан уу?<br>➢ Тийм 5,9%<br>➢ Үгүй –78,2%<br>➢ Үйлчилгээ аваагүй-16%<br>5. Хэрэв тийм бол ямар хүндрэл гарсан талаар бичнэ үү.<br>➢ Эрүүл мэндийн байгууллагаар тусламж үйлчилгээ авахад битүүмж үүссэн, үүсээгүй гэх асуудал хэцүү.<br>➢ Нэгдсэн эмнэлэг дээр 10 мин хүлээдэг.<br>➢ Хөнгөлөлттэй эм цөөн<br>➢ Байгууллагын санхүүжилтийг цаг хугацаанд нь өгч баймаар байна.<br>6. ЭМДХ-ийн албан хаагчдын харилцаа хандлагыг үнэлнэ үү.<br>➢ Маш сайн-32,5%<br>➢ Сайн-44,2%<br>➢ Дунд-17,5%<br>➢ Муу-0%<br>➢ Мэдэхгүй-5,8% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэлбэрээр зохион байгуулж хэрэгжилт үр дүнг тооцон ажиллана.<br>➢ Иргэн даатгуулагчид ЭМДШ-ээ төлөхөд хялбар хурдан болсон, ажил хийдэг төр хариуцах иргэд хамтын төлбөрөөс чөлөөлөгддөг болсонд талархал илэрхийлж байлаа.<br>➢ Тус хэлтсийн албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйг дээдлэн иргэдтэй зав боловсон харьцаж төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүлээгдэл чирэгдэлгүй хүргэн ажиллахад анхаарах болно. | |
| 4.1.6 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана. | - | Албан бичиг өргөдөл, гомдлын тоо шийдвэрлэлтийн хувь | Өргөдөл, гомдлын тоо 417 шийдвэрлэлт 100 хувь | Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна. | Ирсэн албан бичиг-106 үүнээс хариутай 11, явсан албан бичиг-172, ирсэн дотоод албан бичиг-42, явсан дотоод албан бичиг-16, шийдвэрлэлт-100 хувь.<br>Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтөө алдаатай, давхардуулж төлсөн гэх 22 иргэний өргөдлийг хүлээн авч ЭМДЕГ-т уламжлан илгээж бүрэн шийдвэрлүүлсэн. Шийдвэрлэлт 100 хувь.<br>Төр хариуцах иргэний ногдуулалт хийх 17, төрсөн хүүхдийн овог нэр бүртгэх 5, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээлэл шалгуулах 49, эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөгдөх тусламж үйлчилгээний талаар -16 иргэний хүсэлтийг хүлээн авч 100 хувь шийдвэрлэлээ. | 100 |
| 4.1.7 | Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, цаг бүртгэлд хяналт тавих, ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөн туслах, чиглүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | - | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний | Хэлтсийн мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж гүйцэтгэлийг хагас болон бүтэн жилээр дүгнэж ЭМДЕГ-т хүргүүлэн ажилласан | Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна. | 2 албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж Тамгын газарт хүргүүлсэн. Тамгын газрын 2024 оны 04/690 дотоод албан бичгийн дагуу хугацаанд нь дүгнэн дүнгийн нэгтгэл тайланг хүргүүлэх болно. | 100 |
| 4.1.8 | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж | - | Бүрдүүлсэн архивын нэгжийн тоо | 2023 онд 28 боть архивын нэгж үүсгэсэн. | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, журмын дагуу хэрэгжүүлж архивын 12 боть нэгж үүсгэн ЭМДЕГ-т хүлээлгэн өгөхөд бэлэн болгосон. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | бүрдүүлж, ЭМДЕГ-ын архивт хугацаанд хүлээлгэж өгнө. | | | | архивын нэгж бүрдүүлсэн байна. | | |
| 4.1.9 | Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаан, цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнана. | - | Хугацаанд нь тайлагнасан үүрэг даалгаврын тоо, хэрэгжилтийн хувь. | Өгөгдсөн үүрэг даалгаварыг 100 хувь хэрэгжүүлсэн | Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнасан байна. | Удирдлагын шуурхайн хуралдаанд тухай бүр бүрэн оролцож шуурхай хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь бүрэн тайлагнасан. Нийт 20 удаагийн шуурхай хуралд оролцон 17 удаа шуурхайн хурлын биелэлт илгээсэн байна.<br>ЭМДЕГ-ын газар хэлтсүүдээс ирүүлсэн цаг үеийн судалгаа мэдээллийг тухай бүр илгээж ажилладаг. | 100 |

*Төлөвлөгөөг үнэлсэн:*

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ, ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
*(албан тушаал)*

***Төсөвийн шууд захирагч***

............................
*(гарын үсэг)*
*Тэмдэг*

/М.НАРМАНДАХ/

*(огноо)*
2024.12.16

*Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн:*

*ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА*
*(албан тушаал)*

***Нэгжийн дарга***

............................
*(гарын үсэг)*

*/Б.ОЮУНЦЭЦЭГ/*

(огноо)

............................

*Тайлагнасан:*

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА
*(албан тушаал)*

***Нэгжийн дарга***

............................
*(гарын үсэг)*

/С.ДОЛГОРСҮРЭН/
(огноо)

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | | |
|---|---|---|---|---|
| | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Гүйцэтгэл хувь |
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| **2.1 Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх зорилтын хүрээнд** | | | | |
| 2.1.1 | Агентлаг болон бусад байгууллага, төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдах арга зүйн сургалт, семинарт бүрэн оролцоно. | Сургалтад хамрагдсан байна. | Агентлагаас зохион байгуулсан 14, "Мэдээллийн баг" хөтөлбөр-9, аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан 19, Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулдаг "4-7-10" вебинар сургалт-13. ЭМЯ-наас зохион байгуулсан "Цахим эрүүл мэнд", МУЗГ-аас зохион байгуулсан "Төрийн бүтээмж" сургалтуудад тус тус хамрагдан чадавхжиж, гэрээт болон иргэд даатгуулагчдыг цаг үеийн мэдээлэл, арга зүйгээр ханган ажиллаж байна. | 100 |
| 2.1.2 | *Мэргэшлийн кредит цагийн 6 багц цагийн сургалтад хамрагдах* | 6 багц цагийн сургалтад бүрэн хамрагдсан байна. | Эрүүл мэндийн хөгжлийн төвийн лицензийн албаны зохион байгуулдаг мэргэшлийн 5 удаагийн сургалтад хамрагдаж 6 багц цагийн кредитээ баталгаажуулсан. | 100 |
| 2.1.3 | *Англи хэлний сургалтад хамрагдах* | Сургалтад хамрагдаж түвшин | Филипин улсын англи хэлний багш **majean abalos**-н цахим ярианы сургалтад https://meet.google.com/bbr-bdxr- | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | ахисан байна. | wsn?hs=224 линкээр холбогдон 18 удаагийн сургалтад хамрагдаж мэдлэгээ дээшлүүлэн хичээллэж байна. | |

*Төлөвлөгөөг үнэлсэн:* ***Төсвийн шууд захирагч***

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ, ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА .................... (М.НАРМАНДАХ)

2024.12.16 .......... *(огноо)*

*Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:* ***Нэгжийн дарга***

ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА .................... (Б.ОЮУНЦЭЦЭГ)

.............................. *(огноо)*

*Тайлагнасан:* ***НЭГЖИЙН ДАРГА***

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА .................... (С.ДОЛГОРСҮРЭН)

2024.11.27 *(огноо)*